



АЙМГИЙН ИТХ-ЫН VI УДААГИЙН СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ 10-Р ХУРАЛДААН ХУРАЛДЛАА.



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VI удаагийн сонгуулийн X хуралдаан 11 сарын 24-25-ны өдрүүдэд хуралдаж дараахь долоон асуудлыг авч хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. Аймгийн ИТХ-ын 2015-оны тайлангийн

тухай.

2. Увс газрын шинэтгэл, 2016 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тухай.
3. Зарим багийг татан буулгах, шинээр баг байгуулах, өөрчлөлт оруулах тухай.
4. Аймгийн Засаг даргын 2013-2016 оны мөрийн хөтөлбөрийн болон 2015 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтын биелэлт.
5. Аймгийн 2015 оны төсвийн тодотгол.
6. Аймгийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2016 оны төсвийн төслийн тухай.
7. Аймгийн 2016 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтын төсөл.

ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛ

2015.11.06-ны ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар дараах 8 асуудлыг авч хэлэлцлээ.

Үүнд:

1. ЧандманьУвс ХХК-ны зээлийн нөхцөл өөрчлүүлэх тухай.
2. Орон нутгийн өмчийг актлах, балансаас балансад шилжүүлэх асуудал
3. Есүсийн баптист сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл сунгах хүсэлтийг хэлэлцэх
4. Аймгийн ИТХ-ын нэгдсэн хуралдааны тов зарлах тухай
5. Тэс сумын нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системийн үйл ажиллагааг хариуцах ОНӨААТҮГ газар байгуулах тухай
6. Хүнсний худалдааны МИНИ ЗАХ-ын үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн ажлын хэсгийн санал дүгнэлт хэлэлцэх
7. Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр батлах тухай
8. Шагналд тодорхойлох тухай.

2015.11.20-ны ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар дараах асуудлыг авч хэлэлцлээ.

1. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийг шинэчлэн тогтоох тухай
2. Согтууруулах ундаа түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журам
3. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын танилцуулга
4. Үүрдийн хайр сүмийн үйл ажиллагааны зөвшөөрөл сунгах тухай
5. Мал эмнэлэг үржлийн ажил, үйлчилгээний үнэлгээг шинэчлэн тогтоох тухай.
6. Орон нутгийн өмчийг балансаас балансад шилжүүлэх, актлах тухай



2015 ОНЫ А/37 ТООТ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЯВЦЫГ ДҮГНЭВ.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 03-р сарын 24-ны өдрийн А/37 тоот тогтоолоор “Увс аймгийн мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр” баталсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь аймгийн мэргэжлийн боловсрол сургалтыг хөгжүүлж хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлж ажилгүйдлийг бууруулахад оршино.



Уулзалтыг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч аймгийн засаг даргын орлогч Б.Цэцээ, ажлын хэсгийн гишүүн Улаангом Политехник Коллежийн дэд захирал Наранбилэг болон бусад гишүүд хамтран зохион байгуулж хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад гол үүрэг гүйцэтгэх Аймгийн хөдөлмөрийн хэлтэс, Улаангом Коллеж, Ажил, Мэргэжлийн хяналтын газар, Ажил олгогч эдийн холбоо, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Бизнес эрхлэгч, ажил олгогчдын төлөөлөл, Аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчид нийт 17 хүн оролцож хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал, цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарах асуудлуудаар санал солилцож хэлэлцүүлэг өрнүүлэв.

СУМДЫН ИТХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙЛЭЭ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон ЗДТГ-ын хамтарсан хяналт шинжилгээ, мониторингийн 6-н ажлын хэсэг Увс аймгийн 18-н суманд энэ оны 11 сарын 09-14-ний өдрүүдэд ажиллаж сумдын төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг дүгнэж, аймаг, сумын ИТХ-ын бодлого шийдвэр, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, архив албан хэрэг хөтлөлт, төрийн албаны стандартын хэрэгжилт, нийгмийн хөгжлийн бодлого шийдвэрийн хэрэгжилт ОНХС-ын бодлого шийдвэрийн хэрэгжилт, хууль эрх зүйн бодлогын хэрэгжилт, төсөв санхүүгийн бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллалаа.



Хяналт, үнэлгээ шинжилгээний зорилго нь Аймгийн ИТХ-ын ажлын албанаас МУ-ын хууль, ЗГ-ын тогтоол шийдвэр, аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн байдал, сумын ИТХ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэнд хяналт үнэлгээ хийж, сумын ИТХ-аас иргэд, олон нийтийн байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, зөвлөмж өгөхөд оршиж байгаа юм.

ГАЛДАН БОШИГТ ХОРООЛЫН ИРГЭД ХОЛБОО, ИНТЕРНЕТ, ТЕЛЕВИЗИЙН ГУРВАЛСАН СҮЛЖЭЭ АШИГЛАХ НӨХЦӨЛ БҮРДЛЭЭ

“Цахим-увс” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тодорхой хэмжээний төсөв мөнгө баталж, аймгийн иргэдийг шилэн кабел, интернетэд холбох орчин бүрдүүлсэн гэтэл Увс аймагт шинээр баригдсан 27 орон сууцны барилгууд холбооны гаднах шугамын



байгууламж хийгээгүйгээс орон сууцны иргэд холбоо, телевиз, интернетийн гурвалсан үйлчилгээг авч чадахгүйд хүрч байгаа тул аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Ш.Цэдэнбал, Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга Г.Батмөнх, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Цэцгээ, Увс аймгийн МХГ-ын байцаагч Ц.Буджав, МЦХ ТӨХК-ын

мэргэжилтэн Балдорж нар Увс аймагт орон сууцны барилга барьж байгаа кампаниудын төлөөлөл болох Ө.Барсүрэн захиралтай “Амарсанаа” ХХК, Ганхуяг инженертай “Мега макс групп”, Цэгмэд захиралтай “Нарлаг наран” ХХК, Буяннэмэх захиралтай “Увс өргөө” ХХК-ын төлөөлөлтэй уулзаж барилгуудын холбооны гаднах шугамын байгууламжийг Монголын цахилгаан холбоо ТӨХК-тай хамтран үндсэн 3 чиглэлд барилгуудын гаднах холбооны магистрал шугам татаж 12-р сард багтааж орон сууц тус бүрт шилэн кабел оруулахаар тохиролцлоо.



МОНГОЛ УЛСЫН АРДЧИЛСАН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИЙН ӨДӨРТ ЗОРИУЛСАН 2016 ОНЫ ШАТАР СОНИРХОГЧДЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ 4 ДЭХ УДААГИЙН ТЭМЦЭЭНИЙ ЭХЭЛЛЭЭ.



Монгол Улсад шинэ үндсэн хууль баталсан өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд шатрын

спортыг Улсын Их Хурлын дарга ивээлдээ аван нийт орон нутагт шатрыг жигд хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсийг 2012 оноос эхлүүлж, Шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн билээ. Уг тэмцээний цар хүрээг тэлэх зорилгоор анхан шатыг сум, дүүргийн аварга шалгаруулах тэмцээний хүрээнд зохион байгуулж байхаар шийдвэрлэсэн.

Энэ жилийн шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах анхан шатны тэмцээн 2015 оны 11 дүгээр сарын 20-22 өдрүүдэд Увс аймгийн 19 суманд нэгэн зэрэг зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа.

Тэмцээнийг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын тамгын газар, орон нутгийн шатрын холбоо, клубууд хамтран зохион байгуулж байна.

Тэмцээнийг Олон Улсын Шатрын Холбоо /FIDE/-ны дүрмийн дагуу зохион байгуулах ба тэмцээнд оролцогчид нь Монголын шатрын холбооны рейтингийн жагсаалтаар сүүлийн хоёр жилийн хугацаанд 2000-аас дээш гараагүй, шатрын спортын цолгүй, 18-аас дээш насны шатар сонирхогчид оролцох юм.

ӨНДӨРХАНГАЙ СУМ:

УИХ-ын даргын ивээл дор зохион байгуулагдаж байгаа Улсын аварга шалгаруулах шатрын тэмцээний анхан шатны шалгаруулалт сумын аварга шалгаруулах тэмцээнийг 2015 оны 11 дүгээр сарын 20- 22- ны хооронд зохион байгууллаа.

Нийт 19 хүн оролцож 17 эрэгтэй, 2 эмэгтэй шатарчин оролцлоо. Шатрын тэмцээнд 1 байрыг Батсайхан багийн малчин Г. Батбаатар

2 байрыг Цагааннуур багийн малчин Ч. Лхагвасүрэн

3 байрыг Цэцэрлэг багийн өндөр настан Д. Чанзаа нар эзэллээ.

Эмэгтэй шатарчдаас Цагааннуур багийн малчин Ананд түрүүллээ. Түрүүлсэн иргэдэд УИХ-ын даргын гарын үсэгтэй аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох батламжийг гардуулж өглөө.

ХОВД СУМ:

11 сарын 16-17-ны өдөрүүдэд



цас их орж өвөжилт хүндэрсэн Шивэрт багт ажилсан ажлын хэсэгт ИТХ-ын нарийн бичгийн дарга ажиллаж тус багийн 40 наруй айл өрхөөр явж цагийн үеийн ажлын талаар мэдээлэл өгч, төлөөлөгчдэд хуралдааны зар хүргэн зарим хүн хүч муутай айлын өвөлжөө бууцны цас арилгах ажил хийлээ.

УВС АЙМГИЙН УЛААНГОМ ХОТНОО 60 МЕГАВАТТЫН ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭХ ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЦАХИЛГААН СТАНЦ БАЙГУУЛАГДАНА.

“Баруун Монгол энержи” ХХК-ийн захирал Б.Алтангэрэл Герман улс дахь Монгол, Германы хамтарсан “Сакс энержи Монголиа” ХХК-ийн захирал Франк Коккиш нар Увс аймгийн Улаангом хотноо 60



мегаваттын эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Ингэснээр баруун хязгаар нутгийн аймгууд цахилгаан эрчим хүчний хувьд хөрш Оросоос хангагддаг, зарим үед хүндрэлтэй байдал үүсдэг цаг ард хоцрох юм. Энэхүү төслийг хувийн хэвшил төрийн хамтарсан концессийн гэрээгээр хэрэгжүүлэх гэж байгаа бөгөөд 120 сая еврогийн зээлийг “Баруун Монгол энержи” ХХК-ийнхан 40 жилийн дотор өөрийн хөрөнгөөр барагдуулахаар санамж бичигт заасан аж.

ЗАВХАН СУМ:

Өвлийн тэргүүн сарын шинийн нэгэн “ Монгол бахархал”-ын өдөрөөр ИТХ-ын нэрэмжит бөхийн барилдаан зохион байгуулсан. Цолгүй 32 залуу бөхчүүд барилдаж, Шарбулаг багийн залуу бөх Б.Алтансүх түрүүлж, сумын начин цол хүртлээ. Удаахь байрыг Д.Гансүх, Ц.Бат-Өлзий, Ц. Галбадрах нар эзлэв. Мөн сургуулийн сурагчдын дунд ИТХ-ын нэрэмжит шатрын аварга шалгаруулах тэмцээнийг 2 үе шаттай



зохион байгуулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.

ЗҮҮНГОВЬ СУМ:

Шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах анхан шатны тэмцээн зохион байгуулсан ба 10 иргэн оролцлоо. Тэмцээний 1-р байранд иргэн Төмөрсүх, 2-р байранд иргэн Н.Дашочир, 3-р байранд иргэн О.Сайнмэдэг нар шалгарч дараагийн шатанд оролцох эрхийг авлаа. Аймгаас ирсэн Мониторингийн багийнханд ажлаа үзүүлэн холбогдох бичиг баримт судалгааг гаргаж өглөө. -ИТХ-ын дарга мониторингийн багийнхантай Суврага багийн айл өрхүүдээр орж судалгаа аван өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцан хадлан тэжээл бэлтгэлийн ажилтай танилцлаа. Их богд эзэн Чингэс хааны төрсөн өдөр буюу Монгол бахархалын өдрийг бүх албан газрууд иргэдийн дунд тэмдэглэн өнгөрүүлсэн ба уг арга хэмжээний хүрээнд “Дээлтэй-Монгол”, “Сайхан хос” зэрэг арга хэмжээнүүдийг тэмдэглэн өнгөрүүлээ. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан байгууллагуудын дансны үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал